



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн
бүрэлдэхүүн, дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 9.2 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын "Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" 2014 оны 382 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн зөвлөл (цаашид Зөвлөл гэх)-ийн шинэчилсэн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дүрмийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, анагаах ухаан, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, шинэ техник, технологийг нэвтрүүлэх, чанарыг сайжруулахад анхаарч ажиллахыг шинжлэх ухаан, технологийн зөвлөл, түүний гишүүдэд даалгасугай.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай 2015 оны 52 дугаар тушаал, Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай 2009 оны 194 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтыг тус тус хүчингүйд тооцсугай.


САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080108

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 02 сарын 03 өдрийн
33 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: С.Ламбаа, Эрүүл мэнд, спортын яамны төрийн нарийн бичгийн дарга, Эдийн засгийн ухааны доктор (PhD), профессор
- Орлогч дарга: Р.Оюунханд, Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Анагаах ухааны доктор
- Нарийн бичгийн дарга: Д.Цэнджав, Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын Анагаах ухааны технологийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Анагаах ухааны доктор
- Гишүүд:
- Ц.Лхагвасүрэн, Шинжлэх ухааны академийн гишүүн, Монголын анагаах ухааны академийн ерөнхийлөгч, Академич, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
- П.Нямдаваа, Шинжлэх ухааны академийн гишүүн, Монголын анагаах ухааны академийн гишүүн, Академич, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
- Б.Бурмаажав, Монголын анагаах ухааны академийн ерөнхий эрдэмтэн нарийн бичгийн дарга, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
- Т.Эрхэмбаатар, Монголын анагаах ухааны академийн гишүүн, Академич, АШУУИС-ийн Эх барих, эмэгтэйчүүдийн тэнхмийн эрхлэгч, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
- Ц.Содномпил, Монголын анагаах ухааны академийн гишүүн, Академич, Анагаах ухааны доктор, профессор


Я.Энхтөр, Арьс гоо, заслын ерөнхий мэргэжилтэн, АШУҮИС-ийн Арьс судлалын тэнхмийн эрхлэгч, Анагаах ухааны доктор, профессор

Д.Солонго, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Насанд хүрэгчдийн сувилахуйн тэнхмийн эрхлэгч, Сувилахуйн ухааны доктор

Л.Гүндэгмаа, Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн дэд захирал, Биологийн ухааны доктор, дэд профессор

Т.Цэндсүрэн, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Сургалт судалгаа, гадаад харилцааны албаны дарга, Анагаах ухааны доктор

Д.Баян-Өндөр, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Урологийн тасгийн эрхлэгч, Бөөр шилжүүлэн суулгах багийн ахлагч, Анагаах ухааны доктор



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл мэнд, спортын яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөл нь тус яамны захиалгаар гүйцэтгэх эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөх, захиалах, хэрэгжилтийг зохицуулах, төсөлт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, шинжлэх ухаан, технологийн асуудлаар Эрүүл мэнд, спортын яаманд зөвлөх үүрэгтэй.

1.2. Зөвлөл нь эрүүл мэнд, спортын шинжлэх ухааны тулгамдсан асуудлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, эрүүл мэнд, спортын эрдэм шинжилгээний бодлого боловсруулах, асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө хүчийг төвлөрүүлэх, судалгааны ажлын үр дүн, технологийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх ажлыг удирдан зохион байгуулах зорилготой.

Хоёр: Зөвлөлийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Зөвлөлийн бүрэлдэхүүнд анагаах ухааны салбарын эрдэм шинжилгээний ажлын удирдлага, зохион байгуулалтын дадлага, туршлагатай, өндөр мэргэжлийн эрдэмтэдийг оруулна. Зөвлөл нь 25 хүртэл тооны гишүүнтэй байна.

2.2. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэнд, спортын сайдын тушаалаар 4 жилийн хугацаатай батална.

2.3. Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг орлогч дарга, нарийн бичгийн дарга гүйцэтгэнэ. Нарийн бичгийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг зохион байгуулах, зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтлөх, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих, зөвлөлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан бичих, архивын бүрдэл үүсгэн шилжүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

2.4. Зөвлөлийн хуралдаанаас тогтоол, протокол, зөвлөмж гарах бөгөөд тэдгээр нь эрүүл мэнд, спортын сайдын тушаал, бусад шийдвэрийн хэлбэрээр хэрэгжинэ.

2.5. Зөвлөлийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хийнэ. Шаардлагатай үед ээлжит бус хурлыг зохион байгуулна. Хурлыг гишүүдийн ердийн олонхийн ирцтэйгээр хийж, зөвлөлийн хурлаас гарах тогтоол, протокол, зөвлөмжийг гишүүдийн ердийн олонхийн саналаар баталж, дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.6 Зөвлөл нь ЭМСЯ-ны албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдэг, албан бичгийн нүүрийг хэрэглэнэ.

2.7. Зөвлөлийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааны талаар ЭМСЯ-ны сайдын зөвлөлд жил бүр тайлагнана.

Гурав: Зөвлөлийн үүрэг, эрх

Зөвлөл нь дор дурьдсан үүрэгтэй

3.1. Эрүүл мэнд, спортын салбарын эрдэм шинжилгээ, стандарчлал, технологийн бодлого, чиглэл, тулгамдсан зорилтуудыг тодорхойлж, эрдэм шинжилгээний ажлын захиалга, авах, боловсруулах, баталгаажуулах, гүйцэтгэлд хяналт тавих, тайланг хүлээн авах, хэлэлцэх, үр дүнг практикт нэвтрүүлэх, ажлыг хэлэлцэн шийдвэрлэх, зохион байгуулах.

3.2. Эрүүл мэнд, спортын салбарын эрдэм шинжилгээ, стандарчлал, технологийн чиглэлээр хэтийн болон ойрын төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэх, сэргийлэх, анагаах ухааны технологийн хөгжилд ач холбогдол бүхий онол, практикийн асуудал, шинэ арга, эм биобэлдмэл, эмнэлгийн багаж хэрэгслийг хянан хэлэлцэх, турших, практикт нэвтрүүлэх, үйлдвэрлэх, зөвшөөрөл олгох

3.3. Эрүүл мэнд, спортын салбарын хөгжил, байршил шинэчлэл, удирдлага зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэн, санал дүгнэлт гаргах

3.4. Анагаах ухаан, эрүүл мэнд, спортын технологийн өнөөгийн түвшинд үнэлгээ хийх, зөвлөмж дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах.

3.5. Эрдэм шинжилгээний байгууллагуудын зохион байгуулалт, чадавхийг бэхжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх асуудлыг хэлэлцэн, практик өгөөж, үр ашиг багатай удаашралтай хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, судалгааны ажлыг зогсоох хүртэл саналыг холбогдох байгууллагуудад тавих

3.6 ДЭМБ-ын НДББ-ийн хороо, гадаад орнууд, олон улсын байгууллагуудтай анагаах ухаан технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөгжүүлэх

3.7. Анагаах ухааны технологийн ололт, бүтээлийг хүлээн авч, хэлэлцэн дүгнэлт гаргах, шилдэг бүтээл, шилдэг судлаач шалгаруулан урамшуулах, онцгой бүтээл туурвисан эрдэмтэдийг төрийн дээд одон медаль, олон улсын байгууллага, салбарын яамны шагналд нэр дэвшүүлэх

3.8. Шинжлэх ухаан, технологийн ололт, шинэ бүтээл, оновчтой саналыг эрүүл мэнд, спортын салбарын практикт нэвтрүүлэх, эдийн засгийн үндэслэл тооцоо, үр ашгийг хэлэлцэн, мэргэжлийн зөвөлгөө өгөх

3.9. Анагаах ухаан, эрүүл мэнд, спортын мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх, холбогдох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх

3.10. Анагаах ухааны салбарт магистрант, докторант бэлтгэх үндэслэл, захиалга, боловсруулан БСШУЯ-д хүргүүлж, шийдвэрлүүлэх, эрдмийн зэрэг цол олгох, асуудлыг чанаржуулах чиглэлээр анагаахын боловсролын байгууллагуудтай хамтран ажиллах

3.11. Эрүүл мэнд, спортын практикт нэвтрүүлэх ололт туршлага оновчтой санал, шинэ бүтээлийн холбогдох материалд мэргэжлийн үнэлгээ өгөх, бүртгэх, урамшуулах, зохих түшиц байгууллагад турших, нийтийн хүртээл болгох явцад нь хяналт тавих, үр ашгийг тооцох ажлыг зохион байгуулах

Зөвлөл дор дурьдсан эрхтэй

3.12. Зөвлөлөөс эрхлэн салбарын тулгамдсан асуудлаар эрдэм шинжилгээ, практикийн бага хурал, симпозиум, үзэсгэлэн зохион байгуулах

3.13. Эрдэм шинжилгээний байгууллага, төслийн нэгж/багийн ажлыг шалгах, магадлах, түр комисс, шинжээч томилон ажиллуулах, тэдгээрийг татан буулгах

3.14. Зөвлөлийн гишүүдийн ажлыг үнэлж, урамшуулах, журмыг боловсруулан шийдвэрлүүлэх

Дөрөв. Санхүүжилт

4.1. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Эрүүл мэнд, спортын сайдын багцад тусган санхүүжүүлнэ.

4.2. Зөвлөлийн зарим шаардлагатай үйл ажиллагааны зардлыг ДЭМБ болон бусад олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэж болно.